

# **ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 07 дугаар  
сарын 03-ны өдөр

Улаанбаатар  
хот

## **Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатараас 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хорооны 2022 оны 10 дугаар тогтоолоор хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Ц.Сандаг-Очир нар болон холбогдох бусад албан тушаалтнууд ажиллалаа.

Төсвийн байнгын хороо 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын "D.Parliament.mn" цахим системээр дамжуулан олон нийтээс тухайн төсөлтэй холбогдуулан ирүүлсэн болон ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

1. Төсөлд татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг зөвхөн хуулийн этгээд эрхлэх бөгөөд зөвлөх үйлчилгээ эрхлэхдээ бусад татварын мэргэшсэн зөвлөхтэй гэрээгээр хамтарч ажиллах нь нээлттэй байх;

2. Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь даатгалын байгууллагаа өөрөө сонгож, мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулах;

3. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар олгох, гурван түвшний зэрэглэлтэйгээр буюу 1,2 дугаар түвшний эрхийг тав, таван жилийн хугацаагаар, 3 дугаар түвшний зэрэглэлийг хугацаагүй олгох;

4.Татварын мэргэшсэн зөвлөхийн хүрээг нэмэгдүүлэх зорилгоор татвар, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 5-аас доошгүй жил их, дээд сургуульд багшилсан багш, 4-өөс доошгүй жил татварын асуудал эрхэлсэн төрийн байгууллагад ажилласан албан хаагчийг хамруулах;

5.Татварын улсын байцаагчийн ажил, албан тушаалд 10-аас дээш жил ажилласан бол татварын эрх олгох;

6.Мэргэшсэн зөвлөхүүдийн хариуцлага, ёс зүйн асуудлыг хуульчлах үүднээс хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч нь Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаал, хувь хүний нууцад халдах, хувь хүний нууцыг задруулах, залилах, хөрөнгө завших болон эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлсэн болон хувь хүний орлогын албан татварын тайланг хуульд заасан хугацаанд тайлагнаагүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

7.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн орон тооны татварын мэргэшсэн зөвлөх ёс зүйн зөрчил гаргасан талаарх Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн тодорхойлолт болон бусад этгээдээс мэдээлэл ирсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэх;

8.Татварын мэргэшсэн зөвлөх нь зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд харьяалагдахгүйгээр ганцаарчлан татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэхгүй байх;

9.Татварын мэргэшсэн зөвлөхийн чиг үүрэгт татварын хууль тогтоомж, түүний өөрчлөлт, татвар төлөгчийг татварын эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар татвар төлөгчид мэдээлэл, зөвлөгөө өгөхийг үүрэг болгох зэрэг болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Х.Булгантуяа нар болон ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудаар санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.


Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Г.ТЭМҮҮЛЭН**

ТУС3761 9023051390 9087184